



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2017 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛ

Улаанбаатар 2017 он

ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ

2017 оны эхний 9 сарын байдлаар нийслэл хотод 15202 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 1165 хэргээр буюу 8.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Гэмт хэргийн тоо, байршлаар, 2017 оны эхний 9 сараар

Үзүүлэлт	нийслэл	Дүүргүүд								
		Багануур	Багахангай	Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгино-хайрхан	Чингэлтэй	Хан-уул	Налайх
2016.09	14037	223	20	2453	3213	2269	2337	1857	1271	394
2017.09	15202	197	31	2158	4002	2537	2723	1929	1275	350
Нийслэлийн дүнд эзлэх хувь 2017	100.0	1.3	0.2	14.2	26.3	16.7	17.9	12.7	8.4	2.3

Тайлант хугацаанд нийслэл хотод гарсан нийт гэмт хэргийн 4002 буюу 26.3 хувь нь Баянзүрх дүүрэгт гарсан байна. Баянзүрх дүүрэг нь нийслэлийн хамгийн олон хүн амтай дүүрэг бөгөөд 327.1 мянган хүн ам буюу нийслэлчүүдийн 23,7 хувь нь оршин суудаг байна. Баянгол дүүрэгт 214,3 мянган хүн оршин суудаг бөгөөд тайлан хугацаанд 2158 гэмт хэрэг гарсан нь нийслэлд гарсан нийт гэмт хэргийн 14,2 хувь байна. Сүхбаатар дүүрэг 136.6 мянган хүн амтай бөгөөд оны эхний 9 сард 2537 хэрэг гарсан нь нийслэлд гарсан нийт хэргийн 16,7 хувь болж байна. Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 9 сард 2723 гэмт хэрэг гарсан нь нийслэлд гарсан гэмт хэргийн 17.9 хувь болж байна. Сонгинохайрхан дүүрэг нь 315802 хүн амтай бөгөөд 10000 хүн амд 86.2 гэмт хэрэг ногдож байна. Дүүргийн хэмжээнд 2017 оны 7 сард гарсан гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс буурсан бол 8,9 сард гарсан хэргийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн байна.


Хүснэгт 2. Гэмт хэргийн тоо, оны эхний 9 сарын байдлаар

Сар	Нийслэл		Сонгинохайрхан дүүрэг					нийслэлийн дүнд эзлэх хувь 2017.09
	Бүх хэрэг		Бүх хэрэг		Өсөлт, бууралт	Илрүүлэлт %		
	2016	2017	2016	2017		2016	2017	
1	1735	1739	299	252	84.3	59.7	46.9	14.5
2	3220	2987	525	460	87.6	62.2	59.4	15.4
3	4909	4353	822	665	80.9	63.4	65.4	15.3
4	6744	5657	1102	848	77.0	62.7	64.0	15.0
5	8429	7036	1356	1040	76.7	60.8	62.1	14.8
6	10050	8289	1632	1247	76.4	62.4	60.7	15.0
7	11319	10208	1847	1746	94.5	59.9	39.1	17.1
8	12698	12807	2111	2270	107.5	58.5	31.4	17.7
9	14037	15202	2337	2723	116.5	58.1	26.6	17.9

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд оны эхний 9 сарын өссөн дүнгээр 2723 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар өссөн байна.

Дүүрэгт 2017 оны нэгдүгээр сард 252 гэмт хэрэг гарсан нь өнгөрсөн оны нэгдүгээр сараас 47 хэргээр буюу 15.7 хувиар буурсан байна. Хоёрдугаар сард гарсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 26 хэргээс буюу 11.0 хувиар буурчээ. Гуравдугаар сард 212 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 30,5 хувиар буурсан байна. Дөрөвдүгээр сард 196 гэмт хэрэг гарсан нь өмнөх оноос 99 хэргээр цөөн байна. Тавдугаар сард 201 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 86 хэргээр буурсан байна. Зургаадугаар сард 193 хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 113 хэргээр буюу 36,9 хувиар буурсан байна. Долоодугаар сард 687 хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 2.9 дахин өссөн байна. Наймдугаар сард 459 хэрэг гарсан нь өмнөх оноос 1.6 дахин нэмэгджээ. Есдүгээр сард 456 хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 1.8 дахин өссөн байна.


Дүрслэл 1. Гэмт хэргийн тоо, өссөн дүнгээр



Нийслэл хотод 2017 оны эхний 9 сард хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг нийт 4225 гарсан нь өмнөх оны мөн үеэс 218 гэмт хэргээр буюу 5.4 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд Хүнийг санаатай алах гэмт хэрэг 74 гарсан нь өмнөх оны мөн үеэс 16 хэргээр буюу 27.6 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 749 гарсан нь нийслэлд гарсан хэргийн 17.7 хувийг эзэлж байна. Дүүрэгт хүнийг санаатай алах гэмт хэрэг 18 гарсан нь өмнөх оны мөн үетэй адил байгаа бөгөөд нийслэлд гарсан хэргийн 24.3 хувь байна. Нийслэл хотод гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 253 гарсны 25 орчим хувь нь тус дүүрэгт гарсан байна. Дүүргийн хэмжээнд хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 63 гарсан нь өмнөх оны мөн үеэс 27 хэргээр буюу 75.0 хувиар нэмэгдсэн байна. Хүчингийн хэрэг 37 гарсан нь өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өссөн байна.

Нийслэл хотын хэмжээнд оны эхний 9 сарын байдлаар өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 8930 гарсан нь өмнөх оны мөн үеэс 1388 гэмт хэргээр буюу 18.4 хувиар нэмэгдсэн байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 5723 нь буюу 64.1 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлсан гэмт хэрэг эзэлж байна. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өссөн байна.

Дүрслэл 2. Дүүргийн гэмт хэргийн илрүүлэлт, хувиар, сараар




Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард гарсан хэргийн илрүүлэлт 1 сард 46.9 хувь, 2 сард 59.4 хувь, 3 сард 65.4 хувь болж өссөн бол 9 сарын байдлаар 26.6 хувь болж буурсан байна.

Хүснэгт 3. Гэмт хэргийн тоо, төрлөөр, 2017.09

Сар		A	1	2	3	4	5	6	7	8	9	нийслэл ийн дүн эхний 9 сар
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг бүгд	2016		92	151	228	338	409	513	601	686	748	4007
	2017		95	155	216	261	307	367	510	662	749	4225
	Өөрчлөлт		103.3	102.6	94.7	77.2	75.1	71.5	84.9	96.5	100.1	105.4
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууний эсрэг хэрэг бүгд	2016		6	10	13	18	22	27	30	34	36	149
	2017		1	9	13	21	28	32	41	54	63	256
	Өөрчлөлт		16.7	90	100	116.7	127.3	118.5	136.7	158.8	175.0	171.8
Үүнээс: хүчиндэх	2016		4	8	10	14	17	20	25	28	30	110
	2017		0	5	5	9	11	15	23	34	37	146
	Өөрчлөлт		0	62.5	50	64.3	64.7	75.0	92.0	121.4	123.3	132.7
Өмчлөх эрхийн эсрэг хэрэг бүгд	2016		157	289	446	553	674	796	886	999	1126	7542
	2017		106	211	304	396	492	589	876	1215	1554	8930
	Өөрчлөлт		67.5	73.0	68.2	71.6	73.0	74.0	99.2	121.6	138.0	118.4
нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг бүгд	2016		21	39	59	84	101	115	134	152	172	937
	2017		18	37	53	71	90	104	107	109	110	584
	Өөрчлөлт		85.7	94.9	89.8	84.5	89.1	90.4	79.9	71.7	64.0	62.3
Үүнээс: танхайрах	2016		21	39	58	82	99	112	131	152	169	931
	2017		18	37	53	71	90	104	106	109	110	576
	Өөрчлөлт		85.7	94.9	91.4	86.6	90.9	92.9	80.9	73.2	65.1	61.9
Хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг бүгд	2016		6	8	15	20	30	37	42	52	56	215
	2017		5	7	13	17	19	24	24	27	35	173
	Өөрчлөлт		83.3	87.5	86.7	85.0	63.3	64.9	57.1	51.9	62.5	80.5

2017 оны эхний 9 сарын байдлаар гарсан нийт хэргийн 46.8 хувь нь нэгдүгээрт хэлтэст харъяалагдаж байгаа бол 27.1 хувь нь хоёрдугаар хэлтэст, 26.0 хувь нь гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

Дүрслэл 3. Гэмт хэргийн тоо, хувиар, 2017.09 сарын байдлаар



Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 584 гарсан нь өмнөх оны мөн үеэс 353 гэмт хэргээр буюу 37.7 хувиар буурсан байна. Дүүргийн хэмжээнд нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг оны эхний 9 сард 110 гарсан бөгөөд энэ нь танхайрах гэмт хэрэг байна. Танхайрах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 34.9 хувиар цөөн гарсан байна. Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 35 гарсан нь өмнөх оны мөн үеэс 37.5 хувиар цөөн байна.

Дүрслэл 4. Гэмт хэргийн тоо, байршилаар, өссөн дүнгээр



2017 оны эхний 9 сарын байдлаар нийт гарсан гэмт хэргийн 47.2 хувь нь гэр, орон сууцанд гарсан бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 34.2 хувиар өссөн байна. Гэр, орон

сууцанд гарсан хэргийн 616 нь буюу 47.9 хувь нь гэрт, 127 буюу 4.7 хувь нь орон байранд гарсан гэмт хэрэг байна. Тайлант хугацаанд гудамж атлбайд гарсан хэрэг 599 буюу нийт хэргийн 22 орчим хувь болж байна. Нийт гудамж талбайд гарсан гэмт хэргийн 263 нь буюу 43,9 хувь нь гэр хороололд, 25.7 хувь нь орон сууцны хороололд гарчээ. Өмнөх оны мөн үед гэр орон сууцанд нийт 958 хэрэг гарч байсан байна. 2017 оны эхний 9 сарын байдлаар олон нийтийн газарт 249 хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 6 хэргээр буюу 6.0 хувиар нэмэгдсэн байна. Нийслэл хотод гарсан хэргийн 2554 нь буюу 16.8 хувь нь олон нийтийн газарт гарчээ.

Хүснэгт 4. Гэмт хэргийн тоо, хэрэг үйлдсэн байршилаар, өссөн дүнгээр

Сар		1	2	3	4	5	6	7	8	9	нийслэлийн дүн эхний 9 сар	
Гэр, орон сууцанд бүгд	2016	147	258	400	501	598	708	793	871	958	4631	
	2017	95	183	279	350	419	497	730	1024	1286	5483	
	Өөрчлөлт	64.6	70.9	69.8	69.9	70.1	70.2	92.1	117.6	134.2	118.4	
Бүгдээс:	Гэрт	2016	64	99	161	201	241	300	333	359	395	1424
		2017	42	81	129	164	195	224	352	496	616	1811
		Өөрчлөлт	65.6	81.8	80.1	81.6	80.9	74.7	105.7	138.2	155.9	127.2
	Орон сууц, байранд	2016	20	40	47	70	85	99	112	128	143	1203
		2017	16	21	34	45	53	65	86	112	127	1271
		Өөрчлөлт	80	52.5	72.3	64.3	62.4	65.7	76.8	87.5	88.8	105.7
Гудамж, талбайд бүгд	2016	60	104	152	217	286	343	406	500	543	3214	
	2017	74	111	129	170	216	266	389	493	599	3448	
	Өөрчлөлт	123.3	106.7	84.9	78.3	75.5	77.6	95.8	98.6	110.3	107.3	
Бүгдээс:	Гэр хороололд	2016	22	40	67	101	147	176	207	246	269	1019
		2017	28	48	58	76	107	130	176	222	263	1004
		Өөрчлөлт	127.3	120.0	86.6	75.2	72.8	73.9	85.0	90.2	97.8	98.5
	Орон сууцны хороололд	2016	24	37	48	59	69	83	97	121	130	1071
		2017	29	38	41	55	59	74	97	120	154	1162
		Өөрчлөлт	120.8	102.7	85.4	93.2	85.5	89.2	100.0	99.2	118.5	108.5
Олон нийтийн газарт, бүгд	2016	30	57	90	122	145	175	190	214	235	2358	
	2017	22	59	81	100	120	144	175	223	249	2554	
	Өөрчлөлт	73.3	103.5	90.0	82.0	82.8	82.3	92.1	104.2	106.0	108.3	

2017 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд гарсан Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэргийн 2.4 хувь нь хүнийг санаатай алах хэрэг, 10.3 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг, 0.5 хувь нь бусдыг болгоомжгүй алах хэрэг байгаа бол 86.5 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг эзэлж байна. Тайлант хугацаанд Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг өмнөх оны мөн үеэс 3.5 дахин нэмэгдсэн байхад бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 8.1 хувиар буурчээ.

Хүснэгт 5. Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, төрлөөр, өссөн дүнгээр

Сар	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг бүгд			Бүгдээс:											
				Хүнийг санаатай алах			Бусдыг амиа хорлоход хүргэх			ББМГУ хэрэг			Бусдыг болгоомжгүй алах		
Он	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт
1	92	95	103.3	4	3	75	9	3	33.3	78	89	114.1	1	0	0
2	151	155	102.6	5	3	60	9	7	77.8	136	145	106.6	1	0	0
3	228	216	94.7	7	7	100	1	2	200	208	197	94.7	1	0	0
4	338	261	77.2	8	12	150	19	9	47.4	309	238	77.0	2	1	50.0
5	409	307	75.1	11	13	118.8	17	8	47.1	378	285	75.4	3	1	33.3
6	513	367	71.5	12	16	133.3	19	1	5.3	478	348	72.8	3	1	33.3
7	601	510	84.9	14	16	114.3	20	42	2.1 д	563	449	79.8	3	2	66.7
8	686	662	96.5	16	18	112.5	21	62	2.9д	645	579	89.8	3	2	66.7
9	748	749	100.1	18	18	100.0	22	77	3.5д	705	648	91.9	3	4	133.3

Оны эхний 9 сарын байдлаар дүүргийн хэмжээнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1554 гарсан нь өмнөх оны мөн үеэс 428 гэмт хэргээр буюу 38.0 хувиар өссөн байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 72.4 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлсан гэмт хэрэг эзэлж байна. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 296 хэргээр буюу 35.7 хувиар өссөн байна. Бусдын эд хөрөнгө хулгайлах хэргийн 92.3 хувь нь хувийн өмчийг хулгайлсан хэрэг байгаа бөгөөд үүнээс 2.1 хувь нь малын хулгай, 2.0 хувь нь машины хулгай байна.

Хүснэгт 6. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, төрлөөр, өссөн дүнгээр

Он	Сар	Өмчлөх эрхийн эсрэг хэрэг - бүгд	Бүгдээс					
			Бусдын эд хөрөнгө хулгайлах	үүнээс: хувийн өмч хулгайлах	Бусдын эд хөрөнгийг булаах	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	Бусдын эд хөрөнгийг залилах	Бусдын эд хөрөнгийг завших
2016	7	886	661	601	22	36	107	15
	8	999	734	681	25	42	122	18
	9	1126	829	758	25	47	137	21
2017	7	879	619	555	11	59	115	15
	8	1215	868	793	11	88	155	20
	9	1554	1125	1038	11	111	193	21
2017/2016	7	99.2	93.6	92.3	50.0	163.9	107.5	100.0
	8	121.6	118.3	116.4	44.0	209.5	127.0	111.1
	9	138.0	135.7	136.9	44.0	23.4	140.9	100.0


Тайлант хугацаанд гарсан өмчлөх эрхийн эсрэг хэргийн 111 буюу 7.1 хувь нь булаалт бөгөөд өмнөх оны мөн үеэс 14 хэргээр цөөн гарсан байна. Мөн дээрмийн гэмт хэрэг 000 гарсан нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдсэн байна. Харин залилангийн гэмт хэрэг 193 гарсан нь өмнөх оны мөн үеэс 56 хэргээр буюу 40.9 хувиар нэмэгдсэн байна. Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй адилхан байна.

2017 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд гарсан нийт гэмт хэргийн 1461 нь буюу 53.6 хувь нь хөнгөн гэмт хэрэг, 552 буюу 20.3 хувь нь хүндэвтэр гэмт хэрэг байна. Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн 25 орчим хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байгаа бол онц хүнд гэмт хэрэг 35 гарсан нь өмнөх оны мөн үеэс 6 хэргээр буюу 14.6 хувиар буурсан байна. Оны эхний 9 сард нийслэл хотод 173 онц хүнд хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 83 хэргээр буюу 32.4 хувиар цөөн байна. Нийслэлд гарсан онц хүнд хэргийн 20,2 хувь нь тус дүүрэгт ногдож байна. Тайлант хугацаанд 675 хүнд хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 6.1 дахин өссөн бөгөөд нийслэл хотод мөн 4.1 дахин өссөн байна.

Хүснэгт 7. Гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар

Сар	Хөнгөн		өсөлт, бууралт	Хүндэвтэр		өсөлт, бууралт	Хүнд		өсөлт, бууралт	Онц хүнд		өсөлт, бууралт
	2016	2017		2016	2017		2016	2017		2016	2017	
1	112	136	121.4	168	94	56.0	14	19	135.7	5	3	60.0
2	212	223	105.2	279	189	67.7	26	41	157.7	8	7	87.5
3	330	309	93.6	438	292	66.7	40	51	127.5	14	13	92.9
4	463	387	83.6	567	377	66.5	56	59	105.4	16	25	156.3
5	587	477	81.3	678	465	68.6	68	69	101.5	23	29	126.1
6	715	582	81.4	810	552	68.1	78	78	100.0	29	35	120.7
7	837	890	106.3	893	552	61.8	84	264	3.1дах	33	35	106.1
8	976	1237	126.7	1003	552	55.0	96	446	4.6 дах	36	35	97.2
9	1083	1461	134.9	1103	552	50.0	110	675	6.1 дах	41	35	85.4
нийслэлийн дүн эхний 9 сар	6929	8773	126.6	6170	3447	55.9	682	2809	411.9	256	173	67.6

Дүрслэл 5. Гэмт хэргийн тоо, ангилалаар, хувиар, 2017.09 сар



2017 оны эхний 9 сард гарсан гэмт хэргийг цагаар ангилж харвал нийт гэмт хэргийн 25.2 хувь нь 06-14 цагийн хооронд, 29.2 хувь нь 14-19 цагийн хооронд, 14.7 хувь нь 19-22 цагийн хооронд, 30.8 хувь нь 22-06 цагт гарчээ. Эндээс харахад дүүргийн хэмжээнд гарсан нийт хэргийн гуравны нэг буюу 30 орчим хувь нь 19-22 цагийн хооронд гардаг бол 14-19 цагийн хооронд хамгийн бага хэрэг буюу нийт хэргийн 15 орчим хувь нь гарсан байна.

Нийслэл хотод 2017 оны эхний 9 сард гарсан гарсан хэргийн 24.7 хувь нь 06-14 цагийн хооронд, 30.9 хувь нь 14-19 цагт, 14.3 хувь нь 19-22 цагт, 30.1 хувь нь 22-06 цагт гарсан байна.

Хүснэгт 8. Гэмт хэргийн тоо, хэрэг гарсан цагаар, өссөн дүнгээр

Сар	06--14 цаг			14-19 цаг			19-22 цаг			22-06 цаг		
	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт	2016	2017	Өөрчлөлт
1	64	51	79.7	109	71	65.1	40	39	97.5	86	91	105.8
2	103	97	94.2	186	128	68.8	78	81	103.8	158	154	97.5
3	176	145	82.4	276	185	67.0	122	117	95.9	248	218	87.9
4	233	191	82.0	356	243	68.3	172	139	80.8	341	275	80.6
5	296	232	78.4	430	301	70.0	207	157	75.8	423	350	82.7
6	351	274	78.1	516	364	70.5	251	185	73.7	514	424	82.5
7	387	402	103.9	582	502	86.3	277	262	94.6	601	575	95.7
8	451	568	125.9	643	657	102.2	325	333	102.5	692	712	102.9
9	497	686	138.0	705	796	112.9	352	401	113.9	783	840	107.3
нийслэлийн дүн эхний 9 сар	3243	3752	115.7	4299	4697	109.3	2032	2170	106.8	4463	4583	102.7

Оны эхний 9 сард гарсан нийт хэргийн 25.2 хувь нь 06-14 цагийн хооронд гарсан бол нийт энэ цагт гарсан хэргийн 43.0 хувь нь нэгдүгээр хэлтэст ногдож байна. Цагдаагийн хоёрдугаар хэлтэст 06-14 цагийн хооронд гарсан хэргийн 30.0 хувь, гуравдугаар хэлтэст 27.0 хувь нь тус тус ногдож байна. 14-19 цагийн хооронд гарсан хэргийн 44.7 хувь нь нэгдүгээр хэлтсийн, 29.1 хувь нь хоёрдугаар хэлтсийн, 26.1 хувь нь гуравдугаар хэлтсийн хэрэг байсан бол нийт хэргийн 29.2 хувь нь энэ цагт гарчээ.


Хүснэгт 9. Гэмт хэргийн тоо хэрэг гарсан цагаар, хувиар, 2017.09 байдлаар

Үзүүлэлт	06-14 цаг	14-19 цаг	19-22 цаг	22-06 цаг
Цагдаагийн нэгдүгээр хэлтэс	43.0	44.7	41.9	54.3
Цагдаагийн хоёрдугаар хэлтэс	30.0	29.1	32.7	20.2
Цагдаагийн гуравдугаар хэлтэс	27.0	26.1	25.4	25.5
Нийт хэргийн тоо	686	796	401	840
Нийт хэрэгт эзлэх хувь	25.2	29.2	14.7	30.8

Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нийт хэргийн 54.3 хувь нь 22-06 цагт гарсан бол хоёрдугаар хэлтсийн хувьд 20.2 хувь нь энэ цагт гарсан байна. Гуравдугаар хэлтсийн хувьд гарсан хэргүүд цагийн хувьд ойролцоо 06-14 цагийн хооронд нийт хэргийн 27.0 хувь нь гарсан байна. Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хувьд 22-06 цагт хамгийн их хэрэг гарсан

бөгөөд бусад цагуудад гарсан хэргийн тоо ойролцоо байна. Цагдаагийн хоёрдугаар хэлтэст гарсан хэргийн хамгийн бага нь 22-06 цагт гарсан бөгөөд 19-22 цагийн хооронд хамгийн их хэрэг гарсан байна.

Дүрслэл 6. Гэмт хэргийн тоо хэрэг гарсан цагаар, 2017.09 сарын байдлаар




Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт гарсан нийт хэргийн 16.9 хувь нь Даваа гарагт, 13.7 хувь нь Мягмар гарагт, 15.0 хувь нь Лхагва гарагт, 14.7 хувь нь Пүрэв гарагт, 14.8 хувь нь Баасан гарагт, 11.5 хувь нь Бямба гарагт, 13.4 хувь нь Ням гарагт тус тус гарсан байна.

Хүснэгт 10. Гэмт хэргийн тоо, гэмт хэрэг үйлдсэн гарагаар

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	нийслэлийн дүн эхний 9 сар	
Даваа	2016	54	97	163	208	239	284	325	360	395	2252
	2017	54	82	115	140	184	228	306	380	460	2353
	Өөрчлөлт	100	84.5	70.6	67.3	77.0	80.3	94.2	105.6	116.5	104.5
Мягмар	2016	60	99	155	199	239	282	311	355	384	2190
	2017	33	61	93	113	139	169	240	303	372	2186
	Өөрчлөлт	55	61.6	60.0	56.8	58.2	59.9	77.2	85.4	96.9	99.8
Лхагва	2016	66	104	146	191	238	281	317	357	389	2121
	2017	26	55	83	113	147	171	249	336	409	2249
	Өөрчлөлт	39.4	52.9	56.8	59.2	61.8	60.9	78.5	94.1	105.1	106.0
Пүрэв	2016	33	75	132	167	204	245	282	316	352	2047
	2017	32	64	97	123	141	173	249	323	401	2300
	Өөрчлөлт	97.0	85.3	73.5	73.7	69.1	70.6	88.3	102.2	113.9	112.4
Баасан	2016	48	79	110	155	193	232	257	291	327	2031
	2017	45	84	115	140	175	206	267	338	402	2285
	Өөрчлөлт	93.8	106.3	104.5	90.3	90.7	88.8	103.9	116.2	122.9	112.5
Бямба	2016	20	38	65	102	132	165	199	233	264	1733
	2017	33	60	81	104	117	142	207	274	313	1954
	Өөрчлөлт	165	157.9	124.6	102.0	88.6	86.1	104.0	117.6	118.6	112.8
Ням	2016	18	33	51	80	111	143	156	199	226	1663
	2017	29	54	81	115	137	158	223	316	366	1878
	Өөрчлөлт	161.1	163.6	158.8	143.8	123.4	110.5	142.9	158.8	161.9	112.9

Эндээс харахад Даваа гарагт хамгийн их хэрэг гардаг бол Бямба гарагт хамгийн бага хэрэг гарчээ.

Дүрслэл 7. Гэмт хэргийн тоо, үйлдсэн гарагаар




Цагдаагийн нэгдүгээрт хэлтэст оны эхний 9 сард гарсан хэргийн 16.9 хувь буюу хамгийн их хэрэг Даваа гарагт гарсан бол Бямба гарагт хамгийн бага буюу 11.2 хувь нь гарсан байна. Нэгдүгээр хэлтсийн хувьд амралтын өдрүүдэд хамгийн цөөн хэрэг гардаг байна. Цагдаагийн хоёрдугаар хэлтэст гарсан хэргийн хамгийн их нь Даваа болон Баасан гарагуудад гарсан бол Бямба гарагт хамгийн бага хэрэг гарсан байна.

Хүснэгт 11. Гэмт хэргийн тоо хэрэг гарсан гарагаар, хувиар

Үзүүлэлт	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Цагдаагийн хэлтэс 1	16.9	12.8	16.0	15.6	15.4	11.2	11.9
Цагдаагийн хэлтэс 2	16.6	15.0	13.1	13.0	16.4	12.0	13.8
Цагдаагийн хэлтэс 3	17.2	17.2	13.8	14.8	12.0	11.4	15.8
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0


Хоёрдугаар хэлтсийн Лхагва, Пүрэв Ням гарагт гарсан хэргүүдийн тоо ойролцоо байна. Цагдаагийн гуравдугаар хэлтсийн хувьд Баасан Бямба гарагуудад хамгийн бага хэрэг гарч байсан бол Даваа, Мягмар гарагуудад гарсан хэргийн тоо их байна.

Дүрслэл 8. Гэмт хэргийн тоо, гарагаар 2017.09 сарын байдлаар




2017 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд гарсан нийт гэмт хэргийн 8.4 хувийг согтуугаар үйлдсэн нь өмнөх оны мөн үеэс 145 хэргээр цөөрсөн бол нийслэлд гарсан гэмт хэргийн 9.8 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна. Тайлант хугацаанд хүүхэд оролцсон гэмт хэрэг тоо 66 гарсан нь өмнөх оны мөн үеэс 13 гэмт хэргээр буюу 24.5 хувиар өссөн байна.

Дүрслэл 10. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, өссөн дүнгээр




Дүрслэл 11. Хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо, өссөн дүнгээр




Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 9 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 76 гарсан нь нийт гэмт хэргийн 2.8 хувь болж байгаа бол нийслэлд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 405 гэмт хэрэг гарсан нь нийт нийслэлд гарсан хэргийн 2.6 хувь болж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 117 гарсан нь өмнөх оны мөн үеэс 37 хэргээр буюу 46.3 хувиар өссөн байна. Нийслэл хотод тайлант хугацаанд бүлэглэн үйлдсэн 1058 хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 39.2 хувиар өсчээ.

Дүрслэл 12. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, өссөн дүнгээр




Дүрслэл 13. Бүлэглэн үйлдсэн гэмт хэргийн тоо, өссөн дүнгээр



2017 оны эхний 9 сарын байдлаар дүүргийн хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн нийт хүнээс 15.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол 15 хүртэлх настай 12 хүүхэд байна. Харин нийслэл хотод 15 хүртэлх насны 104 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байна.

Дүүргийн хэмжээнд оны эхний 9 сард гэмт хэрэг үйлдсэн хүн амаас 16-17 настай 57 хүн буюу 4.7 хувь, 18-24 настай 271 хүн буюу 22.4 хувь, 25-29 настай 242 хүн буюу 19.9 хувь, 30-34 настай 168 буюу 13.9 хувь, 35-39 настай 158 буюу 13.0 хувь, 40-44 настай 129 буюу 10.7 хувь 45-49 настай 83 буюу 6.9 хувь, 50-54 настай 50 буюу 4.1 хувь, 55-59 настай 27 хүн буюу 2.2 хувь, 60-аас дээш настай хүн 1.2 хувийг тус тус эзэлж байна.

Дүрслэл 14. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны бүлэг ,хувиар



Хүснэгт 13. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр

Сар		1	2	3	4	5	6	7	8	9	нийслэлийн дүн эхний 9 сар
Бүх хүн	2016	215	385	622	845	1035	1267	1410	1605	1773	11055
	2017	170	348	536	676	831	1002	1019	1103	1211	7198
	Өөрчлөлт	79.1	90.4	86.2	80.0	80.3	79.1	72.3	68.7	68.3	65.1
15 хүртэл	2016	1	2	5	6	8	9	13	16	18	112
	2017	2	3	5	6	8	10	10	11	12	104
	Өөрчлөлт	200.0	150.0	100.0	100.0	100.0	111.1	76.9	68.8	66.7	92.9
16-17	2016	10	13	15	19	24	29	33	42	48	372
	2017	5	7	22	34	42	54	54	55	57	289
	Өөрчлөлт	50	53.8	146.7	178.9	175.0	186.2	163.6	131.0	118.8	77.7
18-24	2016	50	91	147	197	236	280	314	399	399	2629
	2017	35	83	124	157	196	230	232	257	271	1616
	Өөрчлөлт	70	91.2	84.4	79.7	83.1	82.1	73.9	64.4	67.9	61.5
25-29	2016	43	102	148	194	242	291	321	365	392	2518
	2017	53	86	107	124	154	196	205	216	242	1563
	Өөрчлөлт	123.3	84.3	72.3	63.9	63.6	67.4	63.9	59.2	61.7	62.1
30-34	2016	51	71	125	163	184	239	255	291	325	1818
	2017	18	44	76	93	109	133	135	147	168	1181
	Өөрчлөлт	35.3	62.0	60.8	57.1	59.2	55.6	52.9	50.5	51.7	65.0
35-39	2016	30	42	69	101	131	152	173	197	211	1307
	2017	23	46	72	92	116	131	131	141	158	802
	Өөрчлөлт	76.7	109.5	104.3	91.1	88.5	86.2	75.7	71.6	74.9	61.4
40-44	2016	15	29	53	77	89	108	131	144	164	975
	2017	15	31	52	73	86	106	107	115	129	658
	Өөрчлөлт	100	106.9	98.1	45.0	96.6	98.1	81.7	79.9	78.7	67.5
45-49	2016	8	14	29	45	62	77	86	96	109	635
	2017	11	25	40	47	61	69	71	79	83	434
	Өөрчлөлт	137.5	178.6	137.9	104.4	98.4	89.6	82.6	82.3	76.1	68.3
50-54	2016	6	16	23	31	36	48	46	58	64	408
	2017	5	16	23	31	32	41	42	44	50	290
	Өөрчлөлт	83.3	100.0	100.0	100.0	88.9	85.4	91.3	75.9	78.1	71.1
55-59	2016	0	3	3	4	12	17	19	20	25	174
	2017	1	4	8	10	16	20	20	25	27	163
	Өөрчлөлт	0	133.3	2.7 дах	2.7 дах	2.7 дах	117.6	105.3	125.0	108.0	93.7
60 дээш	2016	1	2	5	8	11	17	17	17	18	106
	2017	2	3	7	9	11	12	12	13	14	98
	Өөрчлөлт	2 дах	150.0	140.0	112.5	100.0	70.6	70.6	76.5	77.8	92.5

Гэмт хэрэг үйлдсэн хүн амын нийгмийн байдлыг харвал 2017 оны эхний 9 сард нийт гэмт хэрэг үйлдсэн хүн амын 632 буюу 52.2 хувь нь ажилгүй иргэд байна. Гэмт хэрэг үйлдсэн ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 398 хүнээр буюу 38.6 хувиар буурсан байна. Хэрэг үйлдсэн нийт хүн амын 27.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин 9.2 хувь нь

хувийн хэвшлийн ажилтан, 2.8 хувь нь оюутан, 1.9 хувь нь сурагч, 2.2 хувь нь төрийн албан хаагч, 1.8 хувь нь сургууль завсардсан, тэнэмэл хүүхэд байна.

Хүснэгт 14. Гэмт хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	нийслэлийн дүн эхний 9 сар	
ТАХ	2016	9	11	18	21	27	31	30	40	45	308
	2017	5	7	11	20	21	22	22	22	27	205
	Өөрчлөлт	55.6	63.6	61.1	95.2	77.8	71.0	73.3	55.0	60.0	66.6
Хувийн хэвшлийн ажилтан	2016	12	25	33	45	60	83	93	119	130	950
	2017	16	35	50	59	72	90	91	988	111	617
	Өөрчлөлт	133.3	140.0	151.5	131.1	120.0	108.4	97.8	8.3 дах	85.4	64.9
ТББ-ажилтан	2016	1	1	6	11	14	19	21	24	29	185
	2017	3	6	8	14	17	20	21	20	22	108
	Өөрчлөлт	3 дах	6 дах	133.3	127.3	121.4	105.3	100.0	83.3	75.9	58.4
ХХЭ, малчин	2016	12	86	138	209	262	319	362	410	466	2563
	2017	52	97	143	172	215	277	284	314	338	1705
	Өөрчлөлт	433.3	112.8	103.6	82.3	82.1	86.8	78.5	76.6	72.5	66.5
Оюутан	2016	10	15	19	26	30	32	33	38	40	422
	2017	4	6	14	21	25	26	26	30	34	304
	Өөрчлөлт	40	40	73.7	80.8	83.3	81.3	78.8	78.9	85.0	72.0
Сурагч	2016	4	6	10	12	14	18	19	22	23	178
	2017	2	6	9	13	16	22	22	22	23	147
	Өөрчлөлт	50	100	90	108.3	114.3	122.2	115.8	100.0	100.0	82.6
Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	2016	0	2	2	2	4	2	2	2	5	111
	2017	1	10	11	14	18	19	6	19	22	98
	Өөрчлөлт	0	5 дах	5.5 дах	7 дах	4.5 дах	9.8 дах	3 дах	9.5 дах	4.4 дах	88.3
Ажилгүй	2016	126	238	395	517	620	759	844	944	1030	6302
	2017	87	181	290	363	446	524	532	574	632	4003
	Өөрчлөлт	69.0	76.1	73.4	70.2	71.9	69.0	63.0	60.8	61.4	63.5

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн төрийн албан хаагчийн тоо 27 байгаа нь өмнөх оны мөн үеэс 40.0 хувиар буурсан үзүүлэлт байна. Сургууль завсардсан, тэнэмэл хүүхдүүдийн хэрэгт холбогдох нь өмнөх оны мөн үеэс 4.4 дахин өссөн байна. Энэ үзүүлэлт нийслэл хотод 11.7 хувиар өмнөх оны мөн үеэс буурсан байна. Хэрэгт холбогдсон сурагчдын тоо өмнөх оны мөн үетэй адил байна. Хэрэг үйлдсэн оюутны тоо 34 байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар багассан байна. Харин хэрэг үйлдсэн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо 338 байгаа нь өмнөх оны мөн үеэс 128 хүнээр буюу 27.5 хувиар цөөн байна.

2017 оны эхний 9 сарын байдлаар гэмт хэрэг үйлдсэн нийт хүн амын 634 буюу 52.8 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 228 хүнээр буюу 26.1 хувиар буурсан байна. Боловсролгүй хэрэг үйлдсэн хүн 2017 оны эхний 9 сарын байдлаар 42 байгаа өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар буурсан бөгөөд нийслэлд хэрэг үйлдсэн боловсролгүй хүн амын 28.6 хувь болж байна.


Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой 36 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 32.1 хувиар бага байна. Бага боловсролтой 65 хүн хэрэг үйлдсэн нь өмнөх оны мөн үеэс 46.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 15. Гэмт хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшингээр, өссөн дүнгээр

Сар		1	2	3	4	5	6	7	8	9	нийслэлийн дүн эхний 9 сар
Боловсролгүй	2016	11	12	20	24	33	42	51	55	63	193
	2017	2	11	22	30	34	38	38	41	42	147
	Өөрчлөлт	18.2	91.7	110.0	125.0	103.0	90.5	74.5	74.5	66.7	76.2
Бага	2016	8	23	43	55	68	87	97	108	119	374
	2017	8	17	34	38	50	60	61	63	65	305
	Өөрчлөлт	100	73.9	79.1	69.1	73.5	69.0	62.9	58.3	54.6	81.6
Суурь	2016	53	101	162	212	251	298	323	365	402	1316
	2017	37	77	115	141	174	200	205	217	236	972
	Өөрчлөлт	69.8	76.2	71.0	66.5	69.3	67.1	63.5	59.5	58.7	73.9
Бүрэн дунд	2016	108	189	296	417	514	621	697	788	862	3791
	2017	86	179	258	337	419	519	529	582	634	3161
	Өөрчлөлт	79.6	94.7	87.2	80.8	81.5	83.6	75.9	73.9	73.5	83.4
ТМС,Тусгай дунд	2016	9	15	25	32	43	53	55	64	67	304
	2017	7	14	18	22	26	36	36	41	46	248
	Өөрчлөлт	77.8	93.3	72.0	68.8	60.5	67.9	65.5	64.1	68.7	81.6
Дээд	2016	26	45	76	105	126	166	187	225	260	1655
	2017	30	50	89	108	128	149	150	159	188	1492
	Өөрчлөлт	115.4	111.1	117.1	102.9	101.6	89.8	80.2	70.7	72.3	90.2

Тайлант хугацаанд гэмт хэрэг хийсэн суурь боловсролтой 236 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 41.3 хувиар цөөн байна. Нийслэлийн гэмт хэрэг үйлдсэн суурь боловсролтой хүний 24.3 хувь болж байна. Гэмт хэрэг үйлдсэн дээд боловсролтой хүн 188 байгаа нь өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар багассан буюу нийслэлийн нийт хэрэг хийсэн дээд боловсролтой хүний 12.6 хувь байна.

Дүрслэл 15. Гэмт хэрэг үйлдэгсэд боловсролын түвшингээр, өссөн дүнгээр




Тайлант хугацаанд олон нийтийн газарт гарсан хэргийн 24.5 хувь буюу 61 нь дэлгүүрт, 6.8 хувь буюу 17 хэрэг бөөний худалдааны төвүүдэд, 11.6 хувь буюу 29 хэрэг зочид буудалд, 17.7 хувь буюу 44 нийтийн тээвэрт, 27.7 хувь буюу 69 нь бааранд гарсан байна.

Хүснэгт 16. Олон нийтийн газар гарсан гэмт хэрэг, байршилаар, 3-р улиралаар

Он	Сар	Олон нийтийн газарт гарсан хэрэг бүгд	Бүгдээс:					
			Нийтийн зах	Бөөний худалдааны төв	Дэлгүүр	Зочид буудал	Нийтийн тээвэрт	Баар
2016	7	190	4	11	36	24	29	54
	8	214	4	13	42	28	31	50
	9	235	5	16	46	30	40	63
2017	7	175	2	13	48	16	30	58
	8	223	3	14	58	22	35	63
	9	249	4	17	61	29	44	69
2017/2016	7	92.1	50.0	118.2	133.3	66.7	103.4	107.4
	8	104.2	75.0	107.7	138.1	78.6	112.9	126.0
	9	106.0	80.0	106.3	132.6	96.7	110.0	109.5

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн нэгдсэн сан

www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга авч байгааг хүсвэл ЭНД ДАРЖ бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail хаягаа бүртгүүлснээр статистикийн мэдээллийг цаг алдалгүй тогтмол авч байх болно.

SOCIAL NETWORK

[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](https://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)

[www.twitter.com/
statistic_mn](https://www.twitter.com/statistic_mn)

Ухаанаг гар утас, таблет ашиглан статистик мэдээлэл авах ezStat аппликейшн

Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших Монстат аппликейшн



Утсаар:

Лавлах утас
1900-1212



Холбоо барих

18082 Улаанбаатар, Саяхонхайрхан дүүрэг
27-р хороо Агарын гудамж
Дэлхийн зөн ОУБ-ын байр
Утас: 70171322, 70171660
И-мэйл: Songinokhaikhan@nso.mn
Вэб: www.ubstat.mn
www.shd.mn

